



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 439

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох
Тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан нийт 13,433,547,781.00 (арван гурван тэрбум дөрвөн зуун гучин гурван сая таван зуун дөчин долоон мянга долоон зуун наян нэгэн) төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг 1 дүгээр хавсралтад заасны дагуу Улсын ерөнхий прокурорын газрын харьяа нийслэл, дүүрэг, аймгийн Прокурорын газарт эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн нийт 741,301,771.00 (долоон зуун дөчин нэгэн сая гурван зуун нэг мянга долоон зуун далан нэгэн) төгрөгийн балансын үнэ бүхий 2 дугаар хавсралтад заасан барилгын их засварын ажлыг капиталжуулан бүртгэхийг Улсын ерөнхий прокурорын газарт зөвшөөрсүгэй.

3.Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, харьяа аймаг, нийслэл, дүүргийн Прокурорын газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу эзэмшигч байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах:

3.2.Барилгын доорх газар эзэмших эрхийг Прокурорын газрын нэр дээр баталгаажуулж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

133005861
23-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 09 дугаар сарын 27...өдрийн
439...дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

Улсын төсвийн хөрөнгөөр бий болсон, төрийн өмчид бүртгэх
хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон он	Хөрөнгийн үнэ (төгрөг)	Барилга байгууламж ашиглалтад оруулсан улсын комиссын актын дугаар	Хүлээн авч бүртгэх байгууллагын нэр
1	Баянхонгор аймгийн Прокурорын газрын конторын барилга /Баянхонгор аймаг, Баянхонгор сум/	2022.01.18	2,647,730,717.00	2022-01-18 №2022/02	Баянхонгор аймгийн прокурорын газар
2	Өвөрхангай аймгийн Прокурорын газрын конторын барилга /Өвөрхангай аймаг, Арвайхээр сум/	2022.12.30	2,680,648,439.00	2022-12-30 БУ-35/2022	Өвөрхангай аймгийн прокурорын газар
3	Увс аймгийн Прокурорын газрын конторын барилга /Увс аймаг, Улаангом сум/	2023.05.18	2,821,600,000.00	2023-05-18 №2023/03	Увс аймгийн прокурорын газар
4	Хөвсгөл аймгийн Прокурорын газрын конторын барилга /Хөвсгөл аймаг, Мөрөн сум/	2022.07.27	2,612,500,000.00	2022-07-27 ББҚД-67-22/22	Хөвсгөл аймгийн прокурорын газар
5	Багануур дүүргийн Прокурорын газрын конторын барилга /Улаанбаатар хот, Багануур дүүрэг/	2022.09.07	2,671,068,625.00	2022-09-07 БА-198/2022	Багануур дүүргийн прокурорын газар

		13,433,547,781.00	
		(арван гурван тэрбум дөрвөн зуун гучин гурван сая таван зуун дөчин долоон мянга долоон зуун наян нэг)	Нийт дүн

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 09 дугаар сарын 21 өдрийн
439 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

Улсын ерөнхий прокурорын газрын хөрөнгөд
капиталжуулан бүртгэх, барилгын их засварын жагсаалт

д/д	Капиталжуулан бүртгэх хөрөнгийн байршил	Их засварын балансын үнэ (төгрөг)	Ашиглалтанд орсон он	улсын комиссын актын дугаар
1	Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Улсын ерөнхий прокурорын газрын 1-р байр	535,674,913.00	2022	2022-11-07 №/03/2022
2	Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт судалгааны хүрээлэн	205,626,858.00	2022	2022-12-13 №/02/2022
3	Нийт дүн	741,301,771.00 (долоон зуун дөчин нэгэн сая гурван зуун нэг мянга долоон зуун далан нэг)		